

**“Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг
тогтворжуулах (SIFS) дэд хөтөлбөр”-ийн зээлийн
шугамын 9 дэх ашиглалт гарлаа**

Монголбанкнаас жижиглэнгийн нефтийн бүтээгдэхүүнийг хамгийн бага зардлаар санхүүжүүлэхийн зэрэгцээ хил дээрх өртгийн ханшаас хамаарах нөлөөллийг бууруулж, жижиглэнгийн борлуулалтын үнийг тогтвортой байлгах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор SIFS дэд хөтөлбөрийг Уул уурхайн яамтай хамтран 2012.10.26-ны өдрөөс хэрэгжүүлж байгаа билээ.

Энэхүү дэд хөтөлбөрийн 9 дэх транчаар хөтөлбөрт оролцогч банкаар дамжуулан **“Ойн бирж” ХХК, “Синчи Ойл” ХХК, “Ундарга Увс” ХХК, “Хөрс Автосервис” ХХК**-уудад жилийн 3.8%-ийн хүүтэй, 1 жилийн хугацаатай **10.2** тэрбум төгрөгийн санхүүжилтийг 12 дугаар сарын 28-ны өдөр шилжүүллээ.

Түүнчлэн дэд хөтөлбөрт заасны дагуу Монголбанк нь оролцогч банкаар дамжуулан **“Синчи Ойл” ХХК, “Хөрс Автосервис” ХХК, “Ундарга Увс” ХХК, “Ойн бирж” ХХК**-тай нийт 10.2 тэрбум төгрөгтэй тэнцэх ам.долларыг **2-4** сарын дараа худалдах форвард хэлцлийг хамгийн бага зардлаар гүйцэтгэж, ханшийн эрсдлийг нь буурууллаа.

Ийнхүү зээлийн шугамын болон санхүүгийн үүсмэл хэрэгслийн гэрээгээ оролцогч банкуудтай байгуулсан хэрэгжүүлэгч **11 компани нь нийтдээ 93.7** тэрбум төгрөгийн зээлийн шугамыг ашиглаад байна.

Дэд хөтөлбөрийн өмнөх ашиглалт болон хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Монголбанкны цахим хуудасны [“Үнийг тогтворжуулах хөтөлбөр”](#) цэснээс үзнэ үү.